



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/103.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын аварга малчдын шагналын гэрийг Улаанбаатар хотоос Ховд аймагт тээвэрлэхэд зориулсан 2.400.000 төгрөг(хоёр сая дөрвөн зуун мянган)-ийн зардлыг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2.400.000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

